



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 08 сарын 10 өдөр

Дугаар 303

Улаанбаатар хот

Комиссын бүрэлдэхүүнийг  
шинэчлэн батлах тухай

Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2, 19.5 дахь заалтын 19.5.2 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн байгууллагын тусгай зөвшөөрлийн комиссын бүрэлдэхүүнийг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2015 оны "Комиссын бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай" 27 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (Г.Ганчимэг)-д үүрэг болгосугай.

САЙД




Г.ШИЙЛЭГДАМБА

D:\barimt\tushaal

081035



Эрүүл мэнд, спортын сайдын  
2015 оны 08 сарын 10 өдрийн  
303 дугаар тушаалын хавсралт



ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН  
КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Комиссын дарга:

Төрийн нарийн бичгийн дарга

Орлогч дарга:

Төрийн захиргааны удирдлагын газрын  
дарга

Нарийн бичгийн дарга:

Тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааны  
хэрэгжилтийн зохицуулалт хариуцсан  
мэргэжилтэн

Гишүүд:

Стратегийн бодлого төлөвлөлтийн газрын  
дарга

Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг  
зохицуулах газрын дарга

Хяналт - шинжилгээ, үнэлгээ, дотоод  
аудитын газрын дарга

Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга

Эм, эмнэлгийн хэрэгслийн хэлтсийн дарга

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын  
Эрүүл мэнд, боловсролын хяналтын  
газрын Эрүүл мэндийн хяналтын хэлтсийн  
дарга (зөвшилцсөнөөр)

Нийгмийн даатгалын ерөнхий газрын  
дэргэдэх Эрүүл мэндийн даатгалын газрын  
дарга (зөвшилцсөнөөр)